



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/149/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.26 № 52
танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.АРИУНТУНГАЛАГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4foot

• 006020050

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,346,741.36	133,942,069.53
33	АВЛАГА	5,062,066.16	769,938.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,383,105.16	136,677.14
335	Бусад авлага	678,961.00	633,261.00
3351	Байгууллагаас авах авлага	628,961.00	583,261.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	50,000.00	50,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,284,675.20	133,172,131.39
354	Хангамжийн материал	107,284,675.20	133,172,131.39
35410	Бичиг хэргийн материал	99,000.00	441,229.00
35420	Аж ахуйн материал	104,165,105.20	118,813,967.11
35430	Сэлбэг хэрэгсэл	13,834.00	1,385,813.04
35460	Хүнсний материал	41,836.00	819,722.24
35470	Бусад хангамжийн материал	2,964,900.00	11,711,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,651,116,144.00	2,528,815,127.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,651,116,144.00	2,528,815,127.73
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,604,049,894.06	2,482,117,627.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,563,287,437.09	2,447,799,970.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,387,942.34)	(54,194,279.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,800,000.00	9,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,959,999.96)	(3,919,999.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,264,231.23	105,704,231.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,405,024.18)	(67,924,437.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,955,815.66	41,305,815.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,658,673.89)	(27,046,833.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,933,866.60	31,933,866.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,805,030.07)	(16,009,314.11)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	14,025,213.92	14,668,607.72
393	Биет бус хөрөнгө	47,066,249.94	46,697,499.90

39301	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(343,750.06)	(712,500.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,560,000.00	45,560,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,763,462,885.36</u>	<u>2,662,757,197.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>284,920.00</u>	<u>283,920.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	284,920.00	283,920.00
413	Өглөг	284,920.00	283,920.00
4136	Бусад өглөг	284,920.00	283,920.00
41361	Байгууллагад төлөх өглөг	284,920.00	283,920.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,763,177,965.36</u>	<u>2,662,473,277.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,763,177,965.36	2,662,473,277.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,546,930.59	352,546,930.59
51101	Өмч: - төрийн	352,546,930.59	352,546,930.59
512	Хуримтлагдсан үр дүн	1,959,713,389.01	2,119,536,797.74
51210	Өмнөх үеийн үр дүн	1,959,713,389.01	2,220,241,485.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	(100,704,688.10)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	450,917,645.76	190,389,548.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,763,462,885.36</u>	<u>2,662,757,197.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,786,581,383.50</u>	<u>938,578,480.68</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	<u>326,761,955.71</u>
	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	2,115,400,983.50	319,348,393.80
	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	15,873,100.00	7,413,561.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>655,307,300.00</u>	<u>611,816,524.97</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	515,511,000.00	469,845,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	515,511,000.00	469,845,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,400.00	470,629.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,400.00	394,229.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	76,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,719,900.00	141,500,595.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,719,900.00	141,500,595.97

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	669,468,217.09	689,126,194.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	669,468,217.09	689,126,194.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	626,959,734.76	671,228,798.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,279,449.00	363,901,495.00
210101	Үндсэн цалин	273,454,744.50	232,022,458.00
210102	Нэмэгдэл	72,201,770.50	106,139,772.00
210104	Урамшуулал	35,622,934.00	25,739,265.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,208,831.76	47,688,919.99
210201	Тэтгэврийн даатгал	31,790,166.47	34,936,391.10
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,569.16	3,287,283.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,299,190.77	2,610,482.19
210204	Ажилгүйдлийн даатгал	906,296.74	623,160.36
210205	Эрүүл мэндийн даатгал	8,094,608.62	6,231,603.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,238,343.75	140,700,595.97
210301	Гэрэл, цахилгаан	5,427,445.75	4,208,931.97
210302	Түлш, халаалт	130,610,898.00	135,491,664.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,045,150.00	3,741,100.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	79,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,906,250.00	1,573,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	218,500.00	1,237,500.00
210404	Ном, хэвлэл	181,000.00	162,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,900.00	661,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	138,500.00	27,000.00
2105	Нормативт зардал	14,634,496.00	16,731,763.76
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,700.00	313,900.00
210502	Хоол, хүнс	14,264,596.00	15,727,763.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	254,200.00	690,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,000.00	684,288.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	684,288.00
210604	Урсгал засвар	1,142,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	614,500.00	188,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	614,500.00	188,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,698,400.00	432,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,374,400.00	432,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,098,564.25	97,160,435.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,501,384.00	483,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,597,180.25	96,677,435.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,508,482.33	17,897,395.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,141,713.00	7,906,220.96
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,311,713.00	7,491,220.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	415,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,681,175.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,681,175.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,225,256.25	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,225,256.25	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,141,513.08	310,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,141,513.08	310,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,117,113,166.41	249,452,286.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	622,416.40	350,156,974.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	622,416.40	350,156,974.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(622,416.40)	(350,156,974.52)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,116,490,750.01	(100,704,688.10)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(156,777,361.00)	646,687,215.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(156,777,361.00)	646,687,215.35
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,116,490,750.01	2,116,490,750.01
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	1,959,713,389.01	2,763,177,965.36
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	1,959,713,389.01	2,763,177,965.36

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	260,528,096.83	260,528,096.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	2,220,241,485.84	3,023,706,062.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(260,528,096.83)	-	(260,528,096.83)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(100,704,688.10)	(100,704,688.10)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,546,930.59	190,389,548.93	2,119,536,797.74	2,662,473,277.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	655,307,300.00	611,816,524.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	655,307,300.00	611,816,524.97
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	515,511,000.00	469,845,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	515,511,000.00	469,845,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,400.00	470,629.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,400.00	394,229.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	76,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,719,900.00	141,500,595.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,719,900.00	141,500,595.97
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	653,377,300.00	606,631,524.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	653,377,300.00	606,631,524.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	612,697,330.67	587,362,149.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,516,766.00	364,005,417.41
210101	Үндсэн цалин	273,434,451.00	232,126,380.41
210102	Нэмэгдэл	70,459,381.00	106,139,772.00
210104	Урамшуулал	35,622,934.00	25,739,265.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,591,936.92	43,338,569.56
210201	Тэтгэврийн даатгал	36,173,271.63	30,586,040.67
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,569.16	3,287,283.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,299,190.77	2,610,482.19
210204	Ажилгүйдлийн даатгал	906,296.74	623,160.36
210205	Эрүүл мэндийн даатгал	8,094,608.62	6,231,603.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,853,743.75	140,700,595.97
210301	Гэрэл, цахилгаан	6,011,445.75	4,208,931.97
210302	Түлш, халаалт	131,642,298.00	135,491,664.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,009,934.00	10,625,229.00
210401	Бичиг хэрэг	199,384.00	287,429.00
210402	Тээвэр, шатахуун	1,747,850.00	1,573,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	281,500.00	313,500.00
210404	Ном, хэвлэл	181,000.00	238,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,816,400.00	587,500.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,783,800.00	7,625,000.00
2105	Нормативт зардал	17,310,200.00	19,757,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,500.00	313,900.00
210502	Хоол, хүнс	16,307,500.00	16,459,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	863,200.00	2,983,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	820,000.00	5,012,888.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,212,888.00
210604	Урсгал засвар	820,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	614,500.00	188,000.00
210702	Дотоод албан томилолт	614,500.00	188,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,182,250.00	160,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,508,250.00	160,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,798,000.00	3,574,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,798,000.00	2,174,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,679,969.33	19,269,375.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,236,800.00	9,278,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,406,800.00	8,863,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	415,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,400.00	9,681,175.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,400.00	9,681,175.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,225,256.25	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,225,256.25	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,141,513.08	310,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,141,513.08	310,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,930,000.00	5,185,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,930,000.00	5,185,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,930,000.00	5,185,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,930,000.00	5,185,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,900,000.00	5,135,000.00
223001	Бусад хөрөнгө	30,000.00	50,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,930,000.00)	(5,185,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	611602800.00	601664720.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	611602800.00	601664720.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598958200.00	592386520.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364395200.00	364005417.41
210101	Үндсэн цалин	232221400.00	232126380.41
210102	Нэмэгдэл	106170900.00	106139772.00
210104	Урамшуулал	26002900.00	25739265.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47797400.00	43338569.56
210201	Тэтгэврийн даатгал	33605500.00	30586040.67
210202	Тэтгэмжийн даатгал	3528000.00	3287283.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2858400.00	2610482.19
210204	Ажилгүйдлийн даатгал	709600.00	623160.36
210205	Эрүүл мэндийн даатгал	7095900.00	6231603.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140957500.00	140700595.97
210301	Гэрэл, цахилгаан	4450000.00	4208931.97
210302	Түлш, халаалт	135507500.00	135491664.00
210303	Цэвэр, бохир ус	1000000.00	1000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10561400.00	10464600.00
210401	Бичиг хэрэг	203200.00	203200.00
210402	Тээвэр, шатахуун	1573400.00	1573400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	313,600.00	313,500.00
210404	Ном, хэвлэл	162,700.00	162,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	610,100.00	587,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,698,400.00	7,625,000.00
2105	Нормативт зардал	20,955,200.00	19,757,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	314,100.00	313,900.00
210502	Хоол, хүнс	17,605,000.00	16,459,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,036,100.00	2,983,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,300,000.00	10,147,888.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,500,000.00	9,347,888.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	203,200.00	188,000.00
210702	Дотоод албан томилолт	203,200.00	188,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,200.00	160,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,200.00	160,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,628,100.00	3,624,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,228,100.00	2,224,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,644,600.00	9,278,200.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	12,644,600.00	9,278,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,229,600.00	8,863,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	415,000.00	415,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	611,602,800.00	611,345,895.97
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	469,845,300.00	469,845,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	469,845,300.00	469,845,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	141,757,500.00	141,500,595.97
132001	Орон нутгийн төсвөөс	141,757,500.00	141,500,595.97

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	160,629.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	160,629.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	160,629.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	-	160,629.00	
210401	Бичиг хэрэг	-	84,229.00	
210404	Ном, хэвлэл	-	76,400.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	310,000.00	-
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	310,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	470,629.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	470,629.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	394,229.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	76,400.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд нийт 31 багш, ажилтан 205 суралцагч үйл ажиллагаагаа явуулжээ.

Энэ хичээлийн жилд “Суралцагчдад аюулгүй ээлтэй орчин бүрдүүлж, суралцах суурь чадварыг баттай эзэмшүүлэн, эцэг эхний оролцоог нэмэгдүүлэх” гэсэн зорилгыг тавин ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 670,090.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,051.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,538.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100705.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө буурсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	5,062.1	769.9	-4,292.1
Бараа материал	107284.7	133172.1	25887.4
Үндсэн хөрөнгө	2,797,676.60	2,698,622.50	-99,054.1
Нийт хөрөнгө	2,763,462.9	2,662,757.2	-100,705.7
Өглөг	284.9	283.9	-1
Хуримтлагдсан үр дүн	1,959,713.4	2,220,241.5	260,528.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,763462.9	2,662757.2	-100,705.7

Авлага: Тайлант оны эхэнд 5062.1, оны эцэст 769.9 мянган төгрөг болж 4292.1 сая төгрөгөөр буурсан нь НДШ-ийн 4383.1 сая төгрөгийн авлага барагдуулсан байна. Авлагын үлдэгдлийг авч үзвэл ХАОАТатварт 103.9, НДШ 32.8, татварын хэлтсээс хяналтаар тавигдсан ашгийн 10 хувийн татварын авлагад 583.3 мянган төгрөгийн эзэн холбогдогчгүй авлага байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 107284.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 133172.1 мянган төгрөг болж өмнөх оноос 25887.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 54236.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 46822.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 7413.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 28348.6 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 28348.6 сая төгрөг зарцуулж, үнэ төлбөргүй болон акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2,797,676.60 мянга, эцсийн үлдэгдэл 2,698,622.50 мянган төгрөг болж өмнөх оноос 99,054.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5185.0, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 319348.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, хүүхдийн цэцэрлэгт 415456.3, сумын ЗДТГ-т 8131.2 мянган төгрөгийн барилгыг үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр: Өглөг дансны оны эхний 283.9 мянган төгрөгийн үлдэгдэл барагдуулаагүй, эзэн холбогдогчгүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 611602.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 469845.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 141757.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 469845.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 141500.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж 256.9 мянган төгрөгөөр бууруулж 601664.7 мянган төгрөгийг зарцуулж 9681.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 601664.7 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 389.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 4458.8, байр ашиглалт 256.9, нормативд зардал 1145.0, урсгал шилжүүлэг 3366.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас ариутгал халдвар хамгаалал, бичиг хэргийн зардалд зориулж 394.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 84.2 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулж 310.0 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 1.6 хувиар буюу 9681.2 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,

- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт хэмнэлт гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 143 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 5135000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 55 нэр төрлийн 53582112.23 төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 5422.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрч алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж давтан гарсан тул албан шаардлага өглөө.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар байгууллагад биет хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 85721.1 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 103.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, мянган төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй

байх 3 албан шаардлага өгч, 77082.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа:

Тайлант онд ХХОАТ-ын 103922.41 төгрөгийг авлага тусгаагүй нь НББ-ийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.3.бүх өр төлбөр" гэсэн заалтыг зөрчсөн байна. НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу залруулга хийж авлагаар тусгасан.

4.2 Төлбөрийн акт:

4.3 Албан шаардлага:

Тайлант оны санхүүгийн тайлангийн авлага дансны үлдэгдэл 633261, өглөгийн дансны үлдэгдэл 283920 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; " гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Тайлант онд 5135000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Шилэн дансны цахим хуудсанд 143 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6.4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Цалингийн зардлаас 2483000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал баталсан "Эдийн засгийн ангилал батлах тухай" заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 23499.9 сая төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан

шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ тухай бүр нь цахим И-баримтыг хангуулан бүртгэлд тусгаж байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

3.1 Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 45 төрлийн 53582.1 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хасаагүй тайланд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	7	85.6	1	0.1			4	8.6	2	76.9
Дүн										